



“ЭРДЭНЭТ УС, ДТС” ОНӨХК

**“ ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДУЛААНЫ ТООЛУУР”  
НИЙЛҮҮЛЭХ  
ҮНИЙН САНАЛ  
АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: “Эрдэнэт Ус-ДТС “ОНӨХК-ний Эргэлтийн хөрөнгийн дулааны тоолуур нийлүүлэх

/Харьцуулалт/  
гэрээний дугаар: “ЭУДТС”-13/2020

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Оноо: 2020 оны 04-р сарын 20-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: "Эрдэнэт Ус, ДТС "ОНӨХК-ний Эргэлтийн хөрөнгийн дулааны тоолуур нийлүүлэх

Тендер шалгаруулалтын дугаар: "ЭУДТС"-13/2020

"Эрдэнэт Ус, ДТС "ОНӨХК" нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Эргэлтийн хөрөнгийн дулааны тоолуур нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд нийцүүлэн тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгоно.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахимт тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 /Тавин мянган /төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Үнийн саналыг 2020 оны 04 дугаар сарын 30 ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтад илгээнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 04 дугаар сарын 30 өдрийн 10 цаг 30 минутанд "Эрдэнэт Ус, ДТС "ОНӨХК-ний хурлын танхимд нээнэ.

Давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

"Эрдэнэт Ус, ДТС "ОНӨХК-ний захиргааны 106 тоот өрөө  
Материал хангамжийн инженер Д.Болорцэцэг  
e-mail хаяг: /Bolorstetseg920@gmail.com/  
Утас:70358822:95342467

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа
- 1.1. Тендерт оролцогч нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид "ТШӨХ" гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
- 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
- 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. Тендерийн иж бүрдэл
- а. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бурдэнэ. Үүнд:
- (а) Үнийн санал ирүүлэх /маягтын дагуу/
- (б) Нийлүүлэлтийн хуваарь ирүүлэх /маягтын дагуу/
- (в) Улсын бүртгэлийн гэрчилгээг эх хувиас скайнардаж ирүүлэх/
- (г) Санхүүгийн тайлан 2018он, 2019оны аудитлагдсан тайлан ирүүлэх, санхүүгийн тайлан нь алдагдалгүй бөгөөд сүүлийн нэг жилийн борлуулалтын орлого нь батлагдсан төсөвт өртгийн 100% -иас дээш байна.
- (д) Татварын тодорхойлолт ирүүлэх,
- (е) Тендерийн баримт бичгийн ерөнхий болон тусгай нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх
- (ё) Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэх
- (ж) Аж ахуй нэгж байгууллагын танилцуулга - /Тоног төхөөрөмж болон ажиллах хүчин чадавхийг фотожуулсан байдлаар харуулах/
- (з) Одоо хэрэгжиж байгаа гэрээ болон хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаархи мэдээллийг ирүүлэх /Уг мэдээллийг тендерт оролцогчийн гэрээг гүйцэтгэх санхүүгийн болон техникийн чадавхийг үнэлэхэд харгалзан үзнэ.
- (и) Шүүхийн тодорхойлолт
- (й) Ижил төстэй ажлын 2-с доошгүй жилийн туршлагатай байх, туршлагыг харуулсан ажлын гэрээ, гэрээ дүгнэсэн актын хуулбарыг ирүүлэх
- (к) Ижил төстэй Гүйцэтгэсэн ажлын харилцагч байгууллагын тодорхойлолтууд ирүүлэх (л) Мөн тендерт оролцогч нь: захиалагч байгууллага, харъяа татварын байгууллага, эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэс, захиргааны хэргийн анхан шатны шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, харилцагч банк бусад холбогдох байгууллагуудаас тендертэй холбоотой асуудлаар тодорхойлолт авахад татгалзах зүйлгүй гэсэн албан мэдэгдлийг баталгаажуулсан эх хувиар ирүүлэх /аль нэгийг орхигдуулсан тохиолдолд татгалзах үндэслэл болно.
- (м) Тендерт оролцогч нь тендерийн материалд хувь хүний нууцын тухай хууль болон байгууллагын нууцын тухай хуулиар ил болгохыг хориглосон мэдээллийг ялгаж тусад нь ирүүлнэ. Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг

## Нууцлахгүй ирүүлнэ

- (н) Тендерт оролцогч нь уг ажлын техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах этгээдтэй нэгдмэл сонирхолтой эсэх талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх
- (о) Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлэх
- (ө) Тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг тендерт санал болгох тохиолдолд уг барааг хаанаас авах тухай нотлох баримт ирүүлэх
- (р) Монгол улсад ашиглахыг зөвшөөрсөн загварын туршилтанд оруулсан гэрчилгээтэй байх.

<b>4. Тогтмол үнэ</b>	4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нэхцэлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
<b>5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нэхцэлүүд</b>	5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.  5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нэхцэлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
<b>6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа</b>	6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
<b>7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх</b>	7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нэхцэл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
<b>8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл</b>	8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нэхцэлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ (ТШӨХ)**

ТӨӨЗ-НЫ ХОЛБОГОДОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>1.1.1 Үнийн санал ирүүлэх /маягтын дагуу/</p> <p>1.1.2 Нийлүүлэлтийн хуваарь ирүүлэх /маягтын дагуу/</p> <p>1.1.3 Улсын бүртгэлийн гэрчилгээг эх хувиас скайнардаж ирүүлэх/</p> <p>1.1.4 Санхүүгийн тайлан 2018он, 2019оны аудитлагдсан тайлан ирүүлэх, санхүүгийн тайлан нь алдагдалгүй бөгөөд сүүлийн нэг жилийн борлуулалтын орлого нь батлагдсан төсөвт өргтийн 100% -иас дээш байна.</p> <p>1.1.5 Татварын тодорхойлолт ирүүлэх,</p> <p>1.1.6 Тендерийн баримт бичгийн ерөнхий болон тусгай нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх</p> <p>1.1.7 Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэх</p> <p>1.1.8 Аж ахуй нэгж байгууллагын танилцуулга-/Тоног төхөөрөмж болон ажиллах хүчиний чадавхийг фотожуулсан байдлаар харуулах/</p> <p>1.1.9 Шүүхийн тодорхойлолт</p> <p>1.1.10 Ижил төстэй ажлын 2-с доошгүй жилийн туршлагатай байх, туршлагыг харуулсан ажлын гэрээ, гэрээ дүгнэсэн актын хуулбарыг ирүүлэх</p> <p>1.1.11 Ижил төстэй Гүйцэтгэсэн ажлын харилцагч байгууллагын тодорхойлолтууд ирүүлэх</p> <p>1.1.12 Мөн тендерт оролцогч нь: захиалагч байгууллага, харьяа татварын байгууллага, эруул мэнд нийгмийн даатгалын хэлтэс, захиргааны хэргийн анхан шатны шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, харилцагч банк бусад холбогдох байгууллагуудаас тендертэй холбоотой асуудлаар тодорхойлолт авахад татгалзах зүйлгүй гэсэн албан мэдэгдлийг баталгаажуулан эх хувиар ирүүлэх /аль нэгийг орхигдуулсан тохиолдолд татгалзах үндэслэл болно.</p> <p>1.1.13 Тендерт оролцогч нь тендерийн материалд хувь хүний нууцын тухай хууль болон байгууллагын нууцын тухай хуулиар ил болгохыг хориглосон мэдээллийг ялгаж тусад нь ирүүлнэ. Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ</p> <p>1.1.14 Тендерт оролцогч нь уг ажлын техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах этгээдтэй нэгдмэл сонирхолтой эсэх талаар мэдэгдэл эх хувиар ирүүлэх</p> <p>1.1.15 Тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ болон хугацаанд багтаан чанаарын шаардлага хангасан барааг захиалагчид нийлүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлэх</p> <p>1.1.16 Тендерт оролцогч өөрөө үйлдвэрлээгүй барааг тендерт санал болгох тохиолдолд уг барааг хаанаас авах тухай нотлох баримт ирүүлэх Одоо хэрэгжих байгаа гэрээ болон хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаархи мэдээллийг ирүүлэх /Уг мэдээллийг тендерт оролцогчийн гэрээг гүйцэтгэх санхүүгийн болон техникийн чадавхийг үнэлэхэд харгалзан үзнэ.</p> <p>1.1.17 Монгол улсад ашиглахыг зөвшөөрсөн загварын туршилтанд оруулсан гэрчилгээтэй байх.</p>

ТОӨЗ 2.1	<p>Үг тенде р нь цахим тендер шалгаруулалтын журамаар зохион байгуулагдаж байгаа тул Тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>) –нд өөрийн аж ахиун нэгжийн тоон гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр илгээнэ.</p> <p><b>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</b></p> <p>Огноо: 2020 оны 04 дугаар сарын 30 -ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут</p> <p>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээн авахгүй</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд ТЕНДЕРИЙГ ДАРААХ ГАЗАРТ ЦАХИМААР НЭЭНЭ</p> <p>Байгууллагын хаяг: “Эрдэнэт Ус,ДТС “ОНӨХК-ний</p> <p>Давхар болон өрөөний дугаар: “Эрдэнэт Ус,ДТС “ОНӨХК-ний хурлын танхим</p> <p>Аймаг хот: Орхон аймаг, Баян-Өндөр сум</p> <p>Улс: Монгол улс</p> <p>Огноо: 2020 оны 04 дугаар сарын 30- ны өдрийн</p> <p>Цаг: 10 цаг 30 минутанд</p>
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>Багц байхгүй</p>



## ДӨРӨВ: ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- Хэт авианы зарчмаар ажилладаг
- Батерейгаар ажилладаг (6 жил)
- Ашиглалтын хугацаа 15 жилээс багагүй
- Баталгаажуулалт хийгдсэн
- Баталгаажуулалт хоорондын хугацаа 4 жил
- Сүүлийн 36 сарын хэрэглээгээ хянах боломжтой
- Эвдрэл гэмтлээ өөрөө оношилж мэдээллэдэг
- Европын стандарт EN 1434-д нийцсэн
- ISO 9001 стандартад нийцсэн
- Хэт авианы мэдрэгч болон дамжуулагч төхөөрөмжийн боломжит хамгийн хол зайд нь 20м-ээс багагүй

Д/д	Материалын нэр	Үзүүлэлт / Тодорхойлолт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Дулааны тоолуур	DN20, PN25, 2,5м3цаг/ Н	ш	4
2	Дулааны тоолуурын хайрцаг	/Дулааны тоолуурын заалт харах цонхтой байх /Материал-гөлмөн төмерөн Зузаан-0,5-0,8мм Урт-30см Өндөр-20см Өргөн-15см	ш	10

**Барааны тодорхойлолт:** Техникийн тодорхойлолтонд тавьсан шаардлагыг хангасан байна.

**Баглаа боодол:** Ашиглагч байгууллагад хүлээлгэн өгч, бараа хүлээн авсан акт гарган нийлүүлэгч нь тээврийг зардал болон сав баглаа боодлыг хариуцна.

**Хүлээн авах газар:** "Эрдэнэт Ус, ДТС" ОНӨХК-ний байранд

**Бараа нийлүүлэлтийн хуваарь:** / Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн Хуанлын 30 хоногт /

## ТАВ. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

“ЭРДЭНЭТ УС,ДТС “ОНӨХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.БҮҮВЭЙБААТАР танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдолыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.   |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| <b>5. Баталгаат засварын хугацаа</b>                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [тоо] жил байна.  |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| <b>7. Төлбөр</b>  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| <b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| <b>9. Алданги оногдуулах</b>                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |

- 10. Үүргээ  
биелүүлээгү  
й-гээс  
гэрээг  
цуцлах**
- 11. Маргааныг  
шийдвэрлэх**
- 12. Маргааныг  
шийдвэрлэх**
- 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
- 12.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## ДОЛОО.ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших  
(ГЕН-1)**
- 1.1. Монгол улсад ашиглахыг зөвшөөрсөн загварын туршилтанд оруулсан гэрчилгээтэй байх.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бурдүүлэлт  
(ГЕН-2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бурдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд
- 1) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь:
  - 2) Барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт
  - 3) Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ
  - 4) Үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ
  - 5) Барааны гарал үүслийн гэрчилгээ
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээ с өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардалыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар  
(ГЕН-5)**
- 5.1 Баталгаат засварын тусгай шаардлага: (36 сар)
- Барааг засварлах тохиолдолд гэрээнд заасан хугацаанд тухайн засварлагдах тоо хэмжээтэй барааг засварлана.
- 4. Төлбөр (ГЕН-7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:  
Урьдчилгаа /20/ хувийг гэрээ байгуулсаны дараа ажлын 3 хоногт нэхэмжлэх ирсэний дараа төлнэ.  
Гэрээний үнийн дүнгийн / 80/ хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнэ.
- 5. Алданги оногдуулах  
(ГЕН-9)**
- 9.1. Алданги оногдуулах хувь: 0,5 % хоногт  
Алдангийн нийт дүн: Нийт гэрээний үнийн дүнгээс 10% хэтэрвэл гэрээг цуцлана.

## Найм. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### БАТЛАВ

#### ЗАХИАЛАГЧ

#### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

“Эрдэнэт Ус-ДТС “ОНӨХК-ний Эргэлтийн хөрөнгийн дулааны тоолуур нийлүүлэх гэрээ

Дугаар № : “ЭУДТС”-13/2020

Орхон аймаг

Нэг талаас “Эрдэнэт Ус-ДТС “ОНӨХК-ны материал хангамжийн инженер Д.Болорцэцэг (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [ЭУДТС”-13/2020]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл  
Бусад шаардлагатай баримт бичиг  
Үнийн санал  
Гэрээний тусгай нөхцөл  
Гэрээний еренхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь  
Санхүүжилтийн хуваарь

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Материал хангамжийн инженер

Д.Болорцэцэг

[Гарын үсэг]

Хаяг: Орхон аймаг Баян-Өндөр сум  
Хүрэнбулаг баг Сүхбаатарын гудамж

Утас: 70350916

#### НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]